БАТЛАВ
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
А.ДАВААЖАРГАЛ

АТА12931 6594204 9024070548

# ЗҮҮН БҮСЭД ТҮҮХ, СОЁЛЫН НӨӨЦӨД ТҮШИГЛЭСЭН, БУЙР НУУР ОРЧМЫН БОЛОН ХИЛ ДАМНАСАН АЯЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТУСГАЙ БҮСИЙН ТЕХНИК ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны ... дүгээр сарын ...-ны өдөр Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1. | Үндэслэл: | **<u>Хууль эрх зүйн үндэслэл:</u>**<br><br>Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт **“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого**, 2 дугаар хавсралт **“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны:**<br><br>- **Зорилт 1.2.** Үндэсний оюун санаа, өв соёл, сэтгэлгээнд тулгуурласан бүтээгч монгол хүн төвтэй нүүдлийн соёл иргэншлийг хадгалсан тэргүүлэх улс болно.<br>- **Зорилт 4.2.** Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.<br>- **Зорилт 4.4.** Бүс нутгийн эдийн засаг, худалдааны интеграцад нэгдэж, худалдааг хөнгөвчилнө.<br>- **Зорилт 4.5.** Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.<br>- **Зорилт 8.1.** Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.<br>- **Зорилт 8.2.** Эдийн засгийн тэргүүлэх салбарууд болон байршлын давуу талд тулгуурлан бүс, орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлнэ.<br><br>Монгол Улсын Их Хурлын 2024 оны 64 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралт “**Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”:**<br><br>Бүсүүдийн хөгжлийн нийтлэг зорилго:<br><br>**3.5.1.**Зүүн бүсэд түүх, соёлын нөөц, экосистемд түшиглэсэн хил орчмын болон хил дамнасан аяллыг хөгжүүлж, аялал жуулчлалын тусгай бүсийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна. |

| | | |
|---|---|---|
| | | - Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай;<br>- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;<br>- Байгалийн ургамлын тухай хууль /нэн ховор, ховор ургамлын жагсаалт/,<br>- Амьтны тухай хууль<br>- Гамшгаас хамгаалах тухай хууль;<br>- Галын аюулгүй байдлын тухай хууль;<br>- Газрын тухай хууль;<br>- Байгаль хамгаалах олон улсын холбоо /IUCN/-аас гаргасан Тусгай хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлал ба аялагчдын удирдлага, зохион байгуулалт "Тогтвортой хөгжлийн удирдамж" гарын авлага, 2020 он;<br>- Бусад холбогдох дүрэм журам, стандарт, баримт бичиг, Норм, нормативууд |
| 6. | Хийгдэх ажил | Аялал жуулчлалын тусгай бүсийн хөгжлийн нийтлэг концепцийг тодорхойлж, цаашид хөгжүүлэх бодлого, чиглэлийг тодорхойлно.<br><br>Аялал жуулчлалын нөөц даацыг тодорхойлох судалгаа шинжилгээний ажлын хүрээнд:<br><br>- Аялал жуулчлалын нөөц, даацын судалгаа хийж, аялал жуулчлалын голлох бүтээгдэхүүн үйлчигээний өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох;<br>- Түүх соёлын өвийн нөөцийн судалгааг хийж, хууль эрх зүйн хүрээнд хадгалах, хамгаалах, ашиглах арга аргачлалыг тодорхойлох;<br>- Археологийн нөөцийг тодорхойлж аялал жуулчлалын эргэлтэд оруулах боломжийг тодорхойлж судлах<br>- Байгаль орчны хүчин зүйлийн үнэлгээ хийж, Буйр нуурын эко бүс болон амьтан ургамлын тархцад үзүүлэх эерэг, сөрөг нөлөөг тооцох;<br>- Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийн үнэлгээ хийж, бүс нутгийн хөгжилд оролцогч талуудын хамтран ажиллах сонирхлыг тогтоох;<br>- Аялал жуулчлалын дэд бүтэц, тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ, боомт, чөлөөт бүс, тусгай бүсийг хөгжүүлэх боломжийг тодорхойлох;<br>- Гадаад, дотоодын нийт зорчигчдын тоо, жилд үйлчлэх жуулчдын эрэлт, нийлүүлэлтийн хүчин чадлыг судалж, төлөвлөлтийн шийдэл гаргах<br>- Зүүн бүс, Буйр нуур, нуур орчмын рекреацын үнэлгээг хийх<br>- Бүс нутгийн нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн харьцуулсан судалгаа<br>- Бодлогын баримт бичигт хийсэн дүн шинжилгээ<br>- Олон улсын туршлага, чиг хандлага<br>- Архитектур орон зайн төлөвлөлт, ландшафтын хүчин зүйлийн үнэлгээ<br>- Буйр нуур орчимд эко усан аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж<br>- Зүүн бүсийн болон Буйр нуур орчмын аялал жуулчлалын SWOT, TOWS, PESTLE шинжилгээг хийх<br><br>Аялал жуулчлалын орон зайг тодорхойлох |

- Монгол улсын Засгийн газрын болон аймаг, орон нутгийн бодлого, төлөвлөлтийг үндэслэн урт, дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөөтэй уялдааг хангах
- Нийгэм-эдийн засгийн хүчин зүйлийг тодорхойлж аймаг, орон нутгийн хүн амын орлогыг нэмэгдүүлэхэд чиглэх
- Аймаг, орон нутгийн аялал жуулчлалын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэх;
- Тухайн бүс нутаг орчмын аялал жуулчлалын орон зайн төлөвлөлтөд отоглох цэгүүд, эко аяллын бүс, хамгаалах шаардлагатай бүс, бүсчлэлийг тодорхойлох
- Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын менежментийн тогтолцоо, сайн туршлагыг тодорхойлсон зөвлөмж боловсруулах;
- Буйр нуур орчимд аялал жуулчлалын кластер хөгжил, бүс нутгийн таталцлыг тодорхойлох
- Тухайн бүсийн аялал жуулчлалыг орон нутгийн онцлогт тулгуурлан улсын жишиг хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн, эдийн засгийн тэргүүлэх салбарын нэг болох олон улсад өрсөлдөх чадварыг дээшлүүлэх тогтвортой аялал жуулчлалыг тодорхойлж үнэт зүйл, давуу тал, онцлогийг илэрхийлсэн алсын харааг боловсруулах
- Улсын болон орон нутгийн Аялал жуулчлалын бүсийг тодорхойлох
- Монгол Улс болон бүс нутгийн хэмжээнд тухайн төслийн үзүүлэх нөлөөлөл, хөгжүүлэх зорилгыг тодорхойлох
- Аялал жуулчлалын бүсийг хөгжүүлэх зорилтуудыг судалгааны шатанд тодорхойлж гаргах.
- Түүх соёл, байгалийн өвөрмөц тогтоц бүхий газрыг түшиглэсэн амралт жуулчлалын бүс, аялал жуулчлалын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох.
- Буйр нуур орчмын болон дайран өнгөрөх аялал жуулчлалын төрлийг тодорхойлж маршрут гаргах
- Амралт, бааз, отоглох цэгийн үйл ажиллагаа, нуурын хамгаалалт, эрүүл ахуй, хог хаягдлын болон хөрсний бохирдлоос сэргийлэх менежментийн зөвлөмжийг боловсруулах
- Аялал жуулчлалын дэд бүтцийг бүрдүүлэх, хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах
- Төслийн судалгаанд үндэслэн зам дагасан үйлчилгээний барилга байгууламжийн шаардагдах хүчин чадлыг тодорхойлж загвар зураг, ажлын зураг төсвийг боловсруулах
- Төслийн хүрээнд нутгийн иргэдийн олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах барилгын хүчин чадлыг тодорхойлж загвар зураг, ажлын зураг төсөв боловсруулах

Төлөвлөлтийн чиглэлээр:

- Монгол улсын Засгийн газрын болон аймаг, орон нутгийн бодлого, төлөвлөлтийг үндэслэн Зүүн бүсийн үзэл баримтлалыг

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td>тодорхойлж, бүс нутгийн хөгжлийн орчин үеийн чиг хандлагыг тодорхойлох;<br>- бүс нутгийн онцлог, давуу талыг нээн илрүүлж, байгалийн нөөц баялгийг зохистой, өгөөжтэй, хүртээмжтэй ашиглан, эдийн засгийн чиг үүргийг оновчтой тодорхойлох;<br>- үйлдвэр, үйлчилгээг кластерын бодлогоор дэмжиж, бүс дамнасан, салбар хоорондын уялдааг хангах,<br>- бүс нутгийн хөгжилд оролцогч талуудын хамтран ажиллах сонирхлыг тодорхойлон, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдэл ядуурлыг бууруулах боломж, орон нутагт ажиллаж, амьдрах, бизнес эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх;<br>- тээвэр логистикийн нэгдсэн сүлжээ, боомт, чөлөөт бүс, тусгай бүсийг хөгжүүлэх,<br>- Бүсийн орон зайн төлөвлөлтийн хувилбаруудын саналыг боловсруулж,<br>Төлөвлөлтийн хүчин чадлын хувилбарууд<br>- Төслийн хүчин чадлын урьдчилсан тооцоо<br>- Хэтийн тооцооны төсөөлөл, таамаглал<br>- Төслийн үйлчлүүлэгчдийн тооцоо<br>- Төслийн үйлчлүүлэгчдийн хөдөлгөөний урсгал<br>- Төслийн барилга, байгууламжийн суурилагдах хүчин чадлын тооцоо<br>- Орон зайн төлөвлөлтийн санал<br>- Зам тээврийн сүлжээ<br>- Ажиллах хүчний тооцоо<br>- Инженерийн дэд бүтцийн хүчин чадлын тооцоо<br>- Бүтээн байгуулалт, санхүүжилт, хөрөнгө оруулалт<br>- Бүтээн байгуулалтын үе шат, удирдлага<br>- Хөрөнгө оруулалт, санхүүжилт<br>- Төслийн орлогын урьчилсан төсөөлөл<br>- Эрсдэлийн үнэлгээ, удирдлага<br><br>Дүгнэлт, зөвлөмж</td>
</tr>
<tr>
<td>7.</td>
<td>Үйлчилгээ үзүүлэх этгээдэд тавигдах шаардлага</td>
<td>Зөвлөх үйлчилгээ үзүүлэх этгээд нь бүсчилсэн хөшжил, аялал жуулчлалын чиглэлээр судалгаа, зөвлөх үйлчилгээ, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд байна. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээд нь дараах шалгуурыг хангасан байна. Тухайлбал:<br><br>1. Аялал жуулчлалын болон бүс орон нутгийн хөжглийн чиглэлээр судалгаа, зөвлөх үйлчилгээ, бодлогын судалгааны үйл ажиллагаа явуулж байгаа;<br>2. Тухайн байгууллага болон тухайн байгууллагын санал болгож буй зөвлөхүүд нь аялал жуулчлал, бүс орон нутгийн хөгжлийн чиглэлээр судалгаа хийж байсан, тухайн чиглэлээр төрийн бодлого боловсруулах ажилд оролцож байсан туршлагатай (сүүлийн 5 жилийн хугацаанд дээрх чиглэлээр 2 болон түүнээс дээш тосны ажлыг гүйцэтгэсэн);</td>
</tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | 3. Бодлогын судалгаа, стратеги, төлөвлөгөө боловсруулах чиглэлээр ажиллаж байсан туршлагатай (сүүлийн 5 жилийн хугацаанд чиглэлээр 3 болон түүнээс дээш тооны ажлыг гүйцэтгэсэн);<br>4. Олон нийтийн санаа бодлын судалгаа, хэлэлцүүлэг, үндэсний хэмжээнд өргөн хүрээг хамарсан судалгааны мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгэх хүний нөөцийн болон техникийн хүчин чадалтай, ийм хэмжээний ажлыг гүйцэтгэж байсан туршлагатай (сүүлийн 2 жилийн хугацаанд 5 болон түүнээс дээш тооны ажлыг гүйцэтгэсэн);<br>5. Олон нийттэй харилцах, маркетинг сурталчилгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг туршлагатай;<br><br>Хуулийн этгээд нь дараах голлох мэргэжилтнүүдээс бүрдэх багийг ажиллуулах ба зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхэд шаардлагатай бусад хүний нөөцийг бүрдүүлсэн байна.<br><br>Багийн ахлагч нь:<br><br>- Бизнесийн удирдлага, аялал жуулчлалын менежмент, бүс нутгийн удирдлага, нийгмийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;<br>- Судалгаа төлөвлөлтийн чиглэлээр 15 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай;<br>- Сүүлийн 5 жилийн хугацаанд 3 болон түүнээс дээш тооны төрийн бодлого, стратеги боловсруулах ажилд оролцож ажилласан туршлагатай байх.<br><br>Судалгаа, стратеги төлөвлөлтийн мэргэжилтэн- Судлаач;<br><br>- Статистик, социологи, бизнесийн удирдлагын чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;<br>- Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 15 болон түүнээс дээш жил ажилласан туршлагатай;<br>- Төрийн бодлого, стратеги, хууль тогтоомжийн хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 3 болон түүнээс дээш тооны ажлыг гүйцэтгэсэн туршлагатай байх.<br><br>Аялал жуулчлалын судлаач-Зөвлөх:<br><br>- Аялал жуулчлал, бүс нутгийн хөгжил, стратегийн төлөвлөлтийн чиглэлээр докторын зэрэгтэй;<br>- Аялал жуулчлалын чиглэлээр 15 болон түүнээс дээш жил ажилласан, аялал жуулчлалын чиглэлээр 3 болон түүнээс дээш тооны судалгааны ажлыг хэвлүүлсэн туршлагатай байх |
| 8. | Баримт бичгийн иж бүрдэл: | - Судалгаа, үнэлгээ тооцооллын аргачлал арга зүй;<br>/Материалд дүн шинжилгээ хийх, судалгааны үр дүнгийн нэгтгэл, иргэд оршин суугч, төлөвлөлтийн бүсэд хийгдсэн судалгаа зэрэг бусад шаардлагатай материал/<br>- Инженер-геологийн дүгнэлт<br>- Төлөвлөлтийн талаарх танилцуулга |

| | | |
|---|---|---|
| | | - Тухайн нутаг дэвсгэрт ажиллаж, амьдарч буй иргэдээс төлөвлөлтөд тусгах зорилгоор санал асуулга, судалгаа явуулсан байх;<br>- Аялал жуулчлалын маршрут, дэд бүтцийн хангамжийг шийдвэрлэх, төлөвлөлт хийхдээ мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөх, урьдчилсан байдлаар санал авсан байх шаардлагатай;<br>- Авто зогсоол, явган зам, унадаг дугуйн зам, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зам талбай төлөвлөх, тохижилтын ажлын зураг хийх;<br>- Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх талбайг бэлтгэх, хэрэгжүүлэх арга замыг судлан тусгах;<br>- Төлөвлөлтийн шийдлийг эх загвар зураг, эскизийн шатанд зөвшилцөх;<br>- Шинээр боловсруулах ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг өмнө нь хийгдсэн ерөнхий төлөвлөгөөнүүдтэй уялдуулан нэгдсэн шийдэл гаргах;<br>- Зураг төслийг экспертизээр оруулж хянуулах.<br>- Макет III зэрэг (Ерөнхий төлөвлөгөө, ХЕТ)<br>- Авто болон явган аялагчийн нэвтрэх хаалтыг хийхдээ олон улсын жишигт нийцсэн шийдлүүдээс боломжит хувилбарыг сонгох, нэвтрэх хураамжийн төлбөрийг ухаалаг системээр шийдэх арга зам, аргачлалыг гаргах.<br>- Нэн ховор, ховор амьтан, ургамлын жагсаалт, байршлыг 6, 7, 8 дугаар саруудад үзэж болох ургамлын жагсаалтыг нарийвчлан гаргах;<br>- Дээд, доод ургамлын ангилал зүй, зүйлийн бүрэлдэхүүнийг ам тус бүрээр гаргах, холбогдох эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран ажиллах;<br>- Аяллын маршрутыг ховор Амьтан, Ургамалын нягтшил бага газраар төлөвлөх;<br>- Олон улсын стандартын дагуу явган аяллын маршрутыг байгальд ээлтэй байдлаар тохижуулах;<br>- Судалгааны дагуу гарсан материалыг ашиглан мэдээ, мэдээллийн самбарууд төлөвлөх;<br>- Төслийн техник эдийн засгийн үндэслэлийг тодорхойлсон ажлын тайлан 3 хувь цаасан хувилбар, файл хэлбэрээр тус тус ирүүлсэн байна. |
| 10. | Боловсруулах хугацаа, тайлангийн бүрдэл: | Захиалагч, гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээгээр гүйцэтгэх хугацааг үндэслэл болгоно.<br>Эхлэлийн тайлан:<br>- Одоогийн төлөв байдлын судалгаа, байр зүйн зураглал, аялал жуулчлалын нөөц даацыг тодорхойлох судалгаа, инженер геологи, түүхэн барилга байгууламжийн судалгаа дууссан байх, одоогийн байдалд үнэлэлт дүгнэлт хийх, аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөний төлөвлөлтийн тооцоолол боловсруулах;<br>- Дундын тайлан. Эхлэлийн тайланд өгсөн саналыг тусгаж төлөвлөлтийн үе шатанд тавигдах шаардлагын дагуу зураг төсвийг хийж гүйцэтгэсэн байх,<br>- Төлөвлөлтийн шийдлийг олон нийтэд танилцуулж хэлэлцүүлэх /Мэргэжлийн байгууллагууд болон төр захиргааны байгууллагуудад танилцуулж, хэлэлцүүлэг хийх/<br><br>Эцсийн тайлан:Сайдын зөвлөлийн хуралд танилцуулах хурлаас гарсан санал, дүгнэлтийг тусгаж, эцсийн байдлаар хүлээлгэн өгөх; |

| | | |
|---|---|---|
| 11. | Захиалагч байгууллага | Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам |

ХЯНАСАН:
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.БОЛОРМАА

БОЛОВСРУУЛСАН:
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН М.ГАНТУЛГА